

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ
ГАЗРЫН 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН
/2019.11.26-2019.12.10/

2019 оны 12 дугаар сарын 11

Сүхбаатар сум

Тус газар нь 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол улсын хилийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоол, 2018 оны 145,146 дугаар тогтоолоор батлагдсан журмууд болон байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Орон нутаг дахь газрын ажиллах журам”, “Ажил үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж, төрийн үйлчилгээг өөрийн орны болон гадаадын иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэн, төрийн албыг зохих түвшинд зохион байгуулан ажиллаж байна.

2019 оны 12 дугаар сард хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ: Сургалт, хурал зөвлөгөө

Байгууллагаас цаг үеийн асуудлаар зохион байгуулсан 1 удаагийн хуралд газрын 14 албан хаагч хамрагдаж цаг үеийн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авч ажиллаа.

ХОЁР: Хүний нөөцийн талаар

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутаг дахь газрын ажиллах журам”, “Байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Байгууллагын ажил үйлчилгээний стандарт”, “Албан тушаалын тодорхойлолт” болон бусад хууль, тогтоомжийг ажил үүрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус газрын 2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу ээлжийн амралтаа бүрэн эдэлсэн 23, одоо эдлэж байгаа 1 албан хаагч байна. Мөн хяналтын улсын байцаагч Ч.Бямбаа нь байгууллагын даргын баталсан 2019 оны хилийн боомтод ажиллах хуваарийн дагуу 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Ханх” авто замын боомтод үүрэг гүйцэтгэж байна.

ГУРАВ: Ирсэн явсан албан бичиг, өргөдөл гомдлын талаар

Тус газарт төвөөс болон бусад байгууллагаас нийт 7 албан бичиг ирснээс хариутай бичиг ирээгүй байна.

Тайлант хугацаанд хугацаа хоцорсон болон шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа албан бичиг байхгүй байна. Тус газраас 6 албан бичиг бусад байгууллагад хандаж явуулсан байна.

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл, гомдол ирээгүй, албан хаагчаас чөлөө хүссэн 1 өргөдөл ирсэн байна.

ГУРАВ: Виз, бүртгэлийн талаар

Виз олголт:

Тус газрын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу 4 орны 7 иргэнд зохих ангилал, зориулалтын визийг зохих зөвшөөрлөөр олгож ажиллаа. Үүнд:

Австрали-2, Азербайжан-1, Молдав-1, ОХУ-3 иргэн байна. Олгосон визийг төрөл, зориулалтаар нь авч үзвэл: нэг удаагийн орох виз-7 байна.

Визийн хураамж 756.000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан.

Хил орчмын зорчих үнэмлэхээр зорчигч иргэдийн хяналт:

Хялбарчилсан журмаар хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй ОХУ-ын 42 иргэнд бүртгэл хийсэн.

Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд ОХУ-ын 3 иргэнд бүртгэл, хасалт хийн, бүртгэлийн хураамж 5,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Визийн сунгалт:

Албан хүсэлтийн дагуу ОХУ-ын 1 иргэний визийн хугацааг сунгаж, тэмдэгтийн хураамж 109,800 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан.

Оршин суух зөвшөөрөлтэй иргэдийн хасалт:

Тайлант хугацаанд албан хүсэлтийн дагуу БНХАУ-ын 11 иргэний оршин суух үнэмлэхийг хураан авч, хасалт хийсэн байна.

Алдаатай олгогдсон виз:

Тайлант хугацаанд Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар, Өргөмжит консулаас алдаатай олгосон виз бүртгэгдээгүй байна.

ДӨРӨВ: Хяналт, шалгалтын талаар

Нэг. Төлөвлөгөөт хяналт шалгалт

Тус газар нь дарга 1, хяналтын улсын ахлах байцаагч 1, хяналтын улсын байцаагч 6, мэргэжилтэн 6 орон тоотойгоор ажиллаж байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:

Хойд бүс дэх газрын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 14/16 дугаартай удирдамжийн дагуу хяналт шалгалтаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт “Даяан мандал” нөхөрлөлийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд БНХАУ-ын нэр бүхий 2 иргэн нь уурхайн өрөмдлөгийн ажил хийж байсныг илрүүлэн, шалгасан.

БНХАУ-ын нэр бүхий 2 иргэн нь 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “В” ангиллын, 30 хоногтой, нэг удаагийн, орох зориулалттай визтэй Замын-Үүд төмөр замын боомтоор орж ирэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болох нь хяналт шалгалтын явцад авсан фото зураг, зөрчлөө хүлээн зөвшөөрөн гаргасан тайлбар, зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож байна.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн үйлдэлд нь БНХАУ-ын дээрх нэр бүхий 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т зааснаар 2000,000 /нэг зуун мянган/ төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7-д тус тус зааснаар 3 жилийн хугацаанд орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргах саналыг хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

Оногдуулсан торгох шийтгэлийн тухайд:

Тайлангийн хугацаанд зөрчлийн хэрэг нээгээгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 13 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулиар зөрчил гаргасан 3 орны 4 иргэнд 340.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд: БНХАУ-2, Кыргыз-1, ОХУ-1 иргэн байна.

Гадаадын иргэний урьсан 1 аж ахуй нэгж, байгуулагад 2.680.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Торгох шийтгэл оногдуулсныг хүснэгтээр үзүүлбэл:

Газрын нэр	Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
	Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
ХБГ	4	340.000	4	9	2.680.000	-	-	-
Хувь хүнээр 4 гадаадын иргэнд, уригч байгууллагаар 1 аж ахуйн нэгж, байгууллага /9 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулж, нийт 3 сая 20 мянган /3.020.000/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.								

Монгол Улсаас албадан гаргасан талаар: Тайлангийн хугацаанд албадан гаргасан иргэн байхгүй.

№	Улс	Зүйлчлэл				Нийт
		37.1.3	37.1.7	37.1.11	37.1.12	
1						
2						
БҮГД						

Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар: Монгол Улсад орох визгүй болон хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилго тодорхойгүй 4 орны 11 иргэнийг ГИЭЗБТХуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд тус тус заасны дагуу хил нэвтрүүлэлгүй буцааж ажилласан. Үүнд: Тажикстан-1, Гүрж-2, Кыргыз-6, ОХУ-2 иргэн байна.

ТАВ: Мэдээлэл технологийн талаар

Тайлант хугацаанд “Дотоод сүлжээний аюулгүй байдал”, “Мэдээллийн аюулгүй байдал” сэдвээр сургалт бэлтгэн, видео хэлбэрээр газрын албан хаагчид болон төлөөллүүдэд хүргэж ажиллаа. Үүнд:

1. Интернэт коннект ‘Micom Version’ тохиргоо.
2. Дотоод сүлжээний төхөөрөмжийн тохиргоо (M10Сиско)
3. Цахим immigration.gov.mn гэмтэлийг сайжруулах

Мөн тус газрын сарын тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл гомдлын мэдээ болон онцлох мэдээ мэдээллүүдийг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд байршуулж, шинэчлэлт хийн ажиллаа.

Тайлант хугацаанд Алтанбулаг авто зам, Сүхбаатар төмөр замын боомтод сүлжээний тасралт, гэмтлийн талаар дуудлага ирээгүй байна.

ЗУРГАА: Бусад ажлын талаар

Сэлэнгэ аймгийн Дотоод аудитын хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2019/05 дугаар тогтоолын дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалтын танилцуулгыг 12 дугаар сард багтаан хийж Санхүүгийн тайланг НББ-ийн Unicos программын өргөтгөл хийлгэсэн, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга илтгэх хуудсыг бэлтгэсэн, байгууллагын орон сууц, барилга байшинг засварлах, мэдээллийн технологи сүлжээний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулсан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тасралтгүй сургалтад хамруулж хүний нөөцийг хөгжүүлж байгаа олот, эерэг өөрчлөлтүүд гаргаж ажилласныг сайшааж, тус газрын санхүүгийн үйл ажиллагааны хөтлөлт, тайлагналтад 91.2 буюу “БАГА” эрсдэлтэй гэж дүгнэгдлээ.

Цагдаагийн төв байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж буй “ОЙЛГОЁ, ХҮНДЭЛЬЕ” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх ухуулга, нөлөөллийн арга хэмжээнд тус газрын албан хаагчид нэгдэн “Та гэр бүлээ сонсдог уу?”, “Та гэр бүлээ ойлгодог уу?”, “Та гэр бүлдээ итгэдэг үү?” “Та гэр бүлээ хүндэлдэг үү?” Хэрэв та үгүй гэж бөглөсөн бол гэр бүлийн хүндээ захиа бичээрэй аяныг 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж ажиллаа.